

# СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Ц.Пүрэв

Социологийн ухааны доктор.(Ph.D)

Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад болон дотооддоо суралцах, эрдмийн зэрэг хамгаалах, төсөл хөтөлбөрт оролцох зэргээр мэрэгшлээ дээшлүүлсэн социологийн чадварлаг мэргэжилтнүүд олширч, Монголын социологи олон салбар чиглэлээр хөгжиж байгааг тэмдэглэхэд таатай байна. Өөрсдийн явж ирсэн замаа эргэн харж, алдаа оноогоо цэгнэж өнөөгийн хийгдэж буй судалгаандаа үнэлгээ хийж үзээд, цаашид социологийн судалгааны арга зүй аргачлалыг боловсронгуй болгох талаар юун дээр илүү анхаарах шаардлагатай байгаа талаар төрсөн бодол эргэцүүллийг та бүхэнтэй хуваалцаж байна.

Нэг. Онол арга зүйн хэрэглээ. Аливаа шинжлэх ухаан тэр дундаа социологийг онол эмпирикийн нэгдэл талаас нь бид ярьдаг. Гэтэл бидний хийсэн судалгаа онолоос хөндийрөөд, эмпирик тал нь голлох нөхцөл байдал бүрдээд байх шиг санагдах боллоо. Зарим судалгааны дүн болон өөрийнхөө бичиж нийтлүүлсэн зүйлээ харахад баримт, мэдээлэл тоочсон зүйл ихтэй социологийн онол, хавсарга социологийн үүднээс дүгнэсэн, онолын шинжилгээ хийсэн зүйлс хомс байгаа юм.

Социологид амин чухал зүйл бол арга зүйн хандлагыг оновчтой хэрэглэх асуудал. Социологийн арга зүйн хандлагууд позитивизм, шүүмжлэлт социологи, интерпретив хандлага, феминизм, постмодернизмийг судалгаа шинжилгээндээ ашиглах, ялангуяа сүүлийн үед тэдгээрийг нэг асуудлыг шийдвэрлэхэд хослуулан хэрэглэж, онолын триангуляци хийхийг зарим судлаачид чухалчилдаг болжээ. Бид түүнд суралцах хэрэгтэй юм байна. Гадаадын зарим төсөл, судалгаанд оролцож байхад, баримтыг тайлбарлаад бичих гэхээр судлаачийн өөрийнх нь үзэл бодол гээд хэрэгсэхгүй байх тохиолдол цөөнгүй гарч байсан. Сүүлийн үед сургалтанд ч ялгаагүй прагматик сургалт нэрийн дор, онол баримтлалыг орхигдуулах явдал ажиглагдах болов. Энэ бол нэг талын туйлшрал юм.

Дэлхийн социологичдын их хурал дээр (2010) тэргүүлэгч илтгэгчид Өрнөдийн ноёрхлыг зогсоож, Ази, Африк, Латин Америкийн орнуудын социологид өргөн замыг нээж өгөх хэрэгтэй гэсэн байна<sup>1</sup>. Үүнийг нэг талаас тэдгээр орнуудад өөрчлөлт хурдан өрнөж, нийгмийн нийтлэгүүд түүнд янз бүр дасан зохицож байгаа, нөгөө талаас эдүгээжлийн олон янз байдал илэрхий мэдэгдэх болсонтой холбон тайлбарлажээ.

Аливаа нэг орны онцлогт тулгуурласан ерөнхий онол байгуулж болно гэдэгт эргэлзэж байгаа ч, Марксын хэлсэнчлэн Азийн үйлдвэрлэлийн аргад нийцсэн, тэр орнуудын хөгжлийн зүй тогтлыг шинжилж болох ерөнхий онол байж болохыг зарим эрдэмтэд үгүйсгэхгүй байна<sup>2</sup>. Үүнтэй уялдуулан бид Азийн орнуудын социологийг илүү нарийвчлан судлах шаардлагатай байж болох юм.

## **Хоёр. Судалгааны арга барилаа шинэчлэх шаардлага.**

Нийгэм маш хурдан өөрчлөгдөж, эрчимтэй даяарчлагдаж байгааг бид харж байна. Бас судалж ойлгох, танин мэдэхэд төвөгтэй олон үзэгдэл үйл явц илрэх болов. Нийгэм тогтвортой байхад бүтэц-чиг үүргийн хандлага, системийн судалгаа социологид түлхүү хэрэглэгдэж үр дүнд хүрч байсан бол, нийгэм эрс шинэчлэгдэж буй өнөө үед ийм арга зүй тэр бүр тохирохгүй байна гэж судлаачид бичих болов. Иймээс арга зүй арга барилаа шинэчлэх хэрэгцээ үүсч байгаа юм. Өөрчлөлтийн үйл явцыг мэдэхийн тулд богино хугацаанд мониторингийн судалгааг давтан хийж байх шаардлагатай боллоо. Норвегид жил бүр засгийн газар нь үйлдвэрчний эвлэлтэйгээ хамтран олон нийтийн санал асуулга явуулж, хүн ардынхаа амьдралын түвшний өөрчлөлтийг шинжлэн судалдаг ажээ. Ингэхдээ тусгай бэлтгэгдсэн сурвалжлагчдыг ашигладаг юм байна. Мьянмарын ардчиллын удирдагч, Нобелийн энх тайвны шагналт Аун Сан Су Чи “Энгийн иргэдийн өдөр тутмын амьдралд ямар өөрчлөлт авчирснаар

1 В.А Ядов. Всемирный социологический конгресс в Гетеборге-событие, требующее осмысления и действий сообщества социологов // Социологический журнал. 2010.№3.

2 В.А Ядов. Каким мне видится будущее социологии // социс. 2014. № С. 7

ардчиллын үр дүн хэмжигдэнэ” гэж тов тодорхой хэлсэн. Судалгааг шуурхай явуулж үр дүнг түргэн мэдээлж байхгүй бол, энэ хооронд судалгааны объектод өөрчлөлт орж судалгааны баримт хуучрах, хоцрогдох байдалд хүрдгийг бид мэднэ.

Иймээс ШУА- ийн Философийн хүрээлэнгээс эрхлэн сүүлийн хэдэн жилд хэрэгжүүлсэн “Ардчилсан засаглалын төлөв байдал” зэрэг социологийн судалгаа болон олон нийтийн санал асуулгаар нийгмийн сэтгэл зүйд гарч буй өөрчлөлтийг байнга судалж байх хэрэгтэй байгаа юм.

Сүүлийн үед социологийн судалгаа явуулдаг байгууллага төвүүд олохын хамт судалгаа авах хэрэглэгдэхүүнийг бэлтгэхээс эхлээд судалгааны аргачлал, арга техникийн шаардлагыг төдийлөн харгалздаггүй дутагдал их гардаг болж буйг тэмдэглэх нь зүйд нийцнэ. Тухайлбал олон хуудас асуумжаар үнэний хувьтай мэдээлэл авна гэж итгэхэд бэрхтэйг судлаачид байнга анхаарах шаардлагатай санагдана.

Одоогоор судалгааны практикт хэвшээд байгаа судлаачид өөрсдөө хөдөө явж анкетаар мэдээлэл цуглуулах аргыг өөрчилж, орон нутагт (Улаанбаатарт ч ялгаагүй) мэргэжлийн сурвалжлага авагчдыг бэлтгэх, социологийн судалгааны хот хөдөөг холбосон сүлжээг бий болгох, мэдээллийн технологи ашиглан онлайн судалгааг өргөн явуулах, зарим үед телефон гар утас ашиглах зэргээр эдийн засгийн хувьд хэмнэлттэй, цаг хүч хэмнэсэн аргыг судалгаанд нэвтрүүлэх боломж байна. Энэ чиглэлээр үр дүнтэй ажиллаж байгаа зарим судалгааны төвийг дурдаж болно.

IRIM судалгааны хүрээлэн (гүйцэтгэх захирал, социологийн ухааны магистр А. Долгион) судалгааны мэдээлэл цуглуулахдаа таблет, мобайл аппликэйшн ашигладаг юм. Ингэснээр талбараас мэдээллийг цаг тутамд хүлээн авч, хянаж, боловсруулах давуу талууд үүсч байна. Одоогийн байдлаар 10 орчим төслийн мэдээллийг ийм аргаар цуглуулжээ. Мөн энэ хүрээлэнгийнхэн чанарын мэдээлэл боловсруулдаг QDA Miner программыг хэрэглэж байна. Гадаад харилцааны хувьд АНУ дахь Монгол Улсын элчин сайдын яамны дэргэдэх Монгол Соёлын Төвөөс жил бүр зохион байгуулдаг Монгол Судлалын хуралд ажилтнуудаа хоёр дахь жилдээ оролцуулаад байгаа ажээ.

“Хөгжлийн эрэлд” судалгааны төв (захирал нь социологич Б. Амарсайхан) нь судалгааны объект, судлах зүйлийн онцлогт нийцүүлэн эдийн засаг, нийгэм, улс төрийн судалгааг олон улсын арга, аргачлалын дагуу хийдэг.

Сүүлийн жилүүдэд олон нийтийн санал бодлын судалгаа тэр дундаа улс төрийн судалгааны чиглэлээр мэргэжил, ур чадварын өндөр түвшний багийг бүрдүүлэн ажиллуулж байна. Ганцхан жишээ дурдахад хамгийн сүүлд 2013 оны Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн судалгааны ажлыг гүйцэтгэж, нэр дэвшигч 50.17 хувиар ялах болно гэсэн прогноз хийж өгсөн нь сонгуулийн дүнтэй яг тохирсон (50.23 хувьтай гарсан) юм. Энэ төвийн удирдлага мэдээлэл цуглуулах баг, мэдээлэл боловсруулах багийг зохистой бүрдүүлэхэд онцгой анхаарч ажилладаг. Бусад судалгааны байгууллагатай харьцуулахад орон тооны болон гэрээт судлаачиддаа цалин урамшууллыг дунджаар хоёр дахин илүү хэмжээтэй олгодог гэж ярьж байна.

21 аймагт гэрээт судлаачидтай. Иймээс улсын хэмжээг хамарсан ОНСБ-ын судалгааг 4 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн байна. Түүний зэрэгцээ судалгааны төвдөө Монгол улсын олон жилийн статистикийн мэдээллийн санг бүрдүүлсэн бөгөөд жил бүр шинэчлэн баяжуулж байдаг ажээ.

Өнөө үед хийгдэж байгаа судалгааны төслийн зардалд шинжилгээ хийж үзэхэд, судалгаа явуулах зардлын өчүүхэн хувийг мэдээлэл боловсруулах, шинжлэх, тайлан бичихэд зарцуулж ихэнх хэсгийг мэдээлэл цуглуулахад зарж буй. Мэдээллийг шивэх нэг хэмжээст тархалт байгуулахад мөнгө тавиад, бусад статистик болон логик шинжилгээг орхиж тооцдог дутагдал бидэнд байна. Францийн түүхч Куланж “Нэг бүтэн жил анализ хийснийг синтез хийхэд (нэгтгэн дүгнэхэд) ганцхан өдөр хэрэгтэй” гэжээ. Судлаачид олон удаагийн задлан шинжилгээний дүнд шинэ мэдлэг буюу дүгнэлт болохуйц цөөн өгүүлбэр гаргаж авдгийг түүхч эрдэмтэн ийнхүү анхааруулсан хэрэг. Социологийн мэдээлэл боловсруулахдаа SPSS өргөн хэрэглэж буй ч ялангуяа анкетад тоон шинж бага байдаг учраас, шинэ хоёр утгат хувьсагч үүсгэх замаар логик аргаар ангилах, статистик таамаглал шалгах, төрөл бүрийн статистик шинжилгээ, хэв маягчлал, регрессийн шинжилгээ хийж, нийгмийн хөгжлийн хандлагыг тодорхойлох хэрэгтэй байна.

Чанарын мэдээллийн шинжилгээ “шигтгээнээс” хэтрэхгүй байна. Ялангуяа судлаачийн өөрийнх нь дүгнэлт гаргалгаа төдийлөн харагдахгүй байгаа дутагдал ажиглагдсаар байгааг хэн хүнгүй мэднэ.

Хүмүүсийн амьдралын хэв маяг амьдралын түвшин харьцангуй нэг төрөл буюу жигд байх үед улсын хэмжээнд 1000-2000 хүнийг судалгаанд хамруулахад түүврийн төлөөлөх чадвар боломжтой гарч байсан бол, олон хэв маягт соёл дэлгэрч, нийгмийн ялгарал гүзгийрч буй өнөө үед түүврийн дээрхи хэмжээ төлөөлөх чадварыг хангаж чадахгүйд хүрч байна.

Ялангуяа Монголын нийгмийг бүхэлд нь хамарсан томоохон судалгаанд аль нэг бүлэг нийтлэгээс хэтэрхий цөөн хүн хамруулах (тухайлбал малчдын хувьд) явдал байнга гарсаар байгааг дурдахгүй өнгөрч болохгүй. Үүнд бас судалгааны байгууллагын хөрөнгө зардал, хүн хүч, цаг хугацааны боломж хийгээд хүн ардын нутагшилтын онцлог гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг.

Судалгааны шинэ төрлүүдийг эзэмших тухайлбал маркетингийн судалгаа, бодлогын судалгаа, улс төрийн судалгаа, чанарын судалгааны аргыг сургалт судалгаанд өргөн хэрэглэхийг нийгмийн амьдрал шаардах болов.

Гурав. Социологийн судалгааны арга техникийн шинжилгээ. Аливаа нээлтээс илүүтэйгээр ямар аргаар ийм үр дүнд хүрэх гэдэг нь их чухал гэж ярилцдаг. Иймд арга техникийг хэн яаж зохистой хэрэглэсэн, ямар үр дүн гарч буйг судлах нь чухал. Тухайлбал нэг онд хийгдсэн хоёр судалгаагаар айл өрхийн амжиргааны түвшинд үнэлгээ өгүүлэхэд эрс ялгаатай хариулт гарсан байв. Энэ нь асуултынхаа хэлбэрээс болсон уу? эсвэл түүврийн алдаа юу? Үгүй бол энэ хугацаанд үнэхээр хүмүүсийн амжиргааны түвшинд нөлөөлөхүйц үзэгдэл гарснаас (үнийн өсөлт, мөнгөний ханш уналт гэх мэт) болов уу? гэдгийг судалж тогтоох шаардлагатай болно. Польшийн судлаачид асуултын томъёоллоос хамааран хариулт харилцан адилгүй байгааг арга зүйн туршилт явуулж тогтоож байв<sup>3</sup>. Дээрх туршилтаар үндсэн хуульд заалт оруулах, үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэсэн хоёр хэллэгээс хамааран судалгааны дүн харилцан адилгүй гарч байгааг тухайн орны иргэдийн амьдралын хэвшил, зан заншил хийгээд улс төрийн зан төлөвийн онцлогтой холбон тайлбарласан байдаг.

Арга зүй аргачлалаа турших судалгааг сайн хийж, гарч болзошгүй дутагдлаас сэргийлэх ажил хоцрогдох хандлагатай явж ирлээ. Мөн судалгааны хөтөлбөрийн аргазүй болох удиртгал хэсэг нь хэт ерөнхий хийгддэгээс сэдэв зорилгоосоо хамааран тухайн судалгаанд хэрэглэгдэж буй арга зүй, арга техникийн онцлог тал нь сайн харагдахгүй байх тал ажиглагддаг. Ийм асуулт яагаад байх шаардлагатай, энэ асуултыг яаж боловсруулах гэх мэт нь мэдэгддэггүй, анкет, хөтөлбөр зохиохдоо энэ талаар урьдчилан бодож тооцдоггүй дутагдал элбэг тохиолддог.

Судалгааны тайлангуудад анализ хийж, зорилго таамаглалын хэрэгжилт, баримт мэдээлэлд шинжилгээ хийсэн байдал, социологийн ямар ойлголтыг хэрхэн хэрэглэсэн зэргийг судлан үнэлгээ өгөх ажлыг мэрэгжлийн хүрээлэн, салбар, төв, социологичдын холбоо гардан зохион байгуулж, үр дүнг мэрэгжлийн сэтгүүлд нийтэлж байх нь судлаачдын ур чадварыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй санагдана.

Арга зүй аргачлалын чиглэлээр мэрэгжлийн сэтгүүлд өгүүлэл ховор нийтлэгддэгийн дээр доктор, магистр, бакалаврын зэрэг хамгаалж буй бүтээлүүдэд энэ чиглэлийн сэдэв үндсэндээ орхигдсоор ирсэн билээ.

Бид 1980-аад онд малчдаас тэдний өнгөрсөн онд авсан хөдөлмөрийн хөлсийг өөрсдөөс нь асууж бичээд хожим нь баримт бичигтэй тулгаж хариултын үнэний хувьд шинжилгээ хийж байсан. Мөн цуглуулсан мэдээллийн чанарт үнэлгээ өгөх зорилгоор мэдээллийн найдвартай байдал, төлөөлөх чадвар, тогтвортой байдал зэргийг тогтоох оролдлого хийж байсан. Ийм судалгаа одоо ч хэрэгтэй байна. Учир нь цуглуулж байгаа мэдээллийнхээ чанар, үнэний хувьд үнэлгээ дүгнэлт өгөхгүйгээр, олон асуумж цуглуулахыг урьдал болгосноос, хариултыг нэгтгэж гаргасан судалгааны дүн нь бодит үнэнээс хазайж зөрөх явдал гардгийг бид мэднэ.

Дөрөв. Чанарын судалгааны аргыг эзэмших боломж. Чанарын судалгааг оромдох, хэлбэрдэх байдлаар явуулах нь элбэг болсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ихэнхдээ фокус бүлгийн аргыг голлож, Кейсийн судалгаа гэх мэт бусад аргууд бараг хэрэглэгдэхгүй байна.

3 Г. Огрызко-Вевюровский. Версий вопроса при исследовании общественного мнения // Социс. 2003. №6. С. 96-100.

Кейс гэдгийг зарим тохиолдолд хүнтэй нэг удаа уулзсан ярилцлага мэтээр ойлгох явдал ч байна. Эцэст нь чанарын мэдээлэл боловсруулах аргуудыг зохистой ашиглах, ийм мэдээлэл боловсруулах программ хэрэглэж сурах нь чухал юм. Асуулга гэх мэт тоон аргаар судлахад төвөгтэй субъектив мэдээлэл, хүмүүсийн санаа бодол, үйлдэлдээ өгч буй утга учрыг танин мэдэх, энэ талаар цоо шинэ мэдлэг олж авах зорилгоор чанарын судалгааны аргуудыг хэрэглэдэг. Гэтэл ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын асуулт нь хэмжээгээр дэндүү их, сурвалжлагын асуулт шиг болсон тохиолдол их гардаг.

Чанарлаг мэдээлэлд хийсэн боловсруулалтаас үзэхэд тайланд хариулагчийн үзэл бодол, үг өгүүлбэр, хэллэгийг голлон оруулаад, харин түүнд тулгуурлан судлаачийн өөрийн хийсэн дүгнэлт бараг байдаггүй тал ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, тоочин бичиглэхүй буюу Веберийн хэлснээр судалгаанд оролцогчдын үйлдлийг “шууд ажиглан ойлгох” –оос үйлдлийн утга учрыг тайлбарлан ойлгохуйд, Страусын үзэл баримтлалаар бол, нээлттэй кодоос тэнхлэгийн болон түүвэр кодоод шилжүүлэн хувиргах арга барилд суралцах хэрэгтэй болж байна.

Сүүлийн үед эх бичвэрийг шинжилдэг компьютерийн олон программ гарч, манай социологичид тэдгээрээс судалгаандаа хэрэглэдэг болж байгаа нь сайшаалтай. Тухайлбал Монреаль дахь Pvovalis Research компани боловсруулсан QDA Miner v. 2.08 (Word Star v.5.1.12 модультай) программыг МУИС-ийн эдийн засгийн болон социологийн тэнхимийн багш нар чанарын судалгааны мэдээлэл боловсруулахдаа хэрэглэсэн байна. МУ-ын ҮСХ-оос эрхлэн явуулсан зарим судалгаанд NVivo 2.0 программ хэрэглэн бичвэр мэдээлэлд шинжилгээ хийсэн зэргийг дурдаж болно.

“Үргэлжийн эрэл хайгуул байнгын бясалгал хийх сэтгэл зүй давамгайлсан чөлөөт задгай сэтгэлгээтэй<sup>4</sup>” (Балхаажав) Монголчуудын хувьд энэ аргыг хэрэглэх суурь дэвсгэр, бидний сэтгэлгээний арга барилд угаасаа байгаа хэмээн үзэж байгаа. Нөгөө талаас ямар нэг номлол хөгжлийн аль нэг загварын онолоос эсвэл дур мэдэн гаргаж ирээд, түүндээ нийгмийг зохицуулах гэх буюу түүгээр явахыг албадаж шахдаггүй, гагцхүү амьдралыг жинхэнэ байгаагаар нь судалж ухаарахыг эрмэлздэг, хатуу хайрцаглаад барьчихсан номлол бус харин гүнзгий бөгөөд задгай чөлөөт сэтгэлгээ гэж үздэг (Г.Лувсанцэрэн) буддын гүн ухааны төв үзлийн арга зүйтэй<sup>5</sup> олон талаар төстэй байгааг тэмдэглэн хэлж болно.

Академич Г.Чулуунбаатар (этно арга зүй), доктор (Sc.D), профессор Ч. Ган-Өлзий (феноменологи философи) нар чанарын судалгааны зарим аргыг Монголын эрдэмтэд хэрхэн хэрэглэж байсан болон сургалт судалгаанд ашиглах боломж нөхцөлийн талаар сонирхолтой ном өгүүлэл нийтлүүлсэн нь чухал ач холбогдолтой. Манайд хэл шинжлэл түүх уран зохиол, шашин судлаачид энэ аргыг философичдоос өмнө хэрэглэж ирснийг<sup>6</sup> тэнд цохон тэмдэглэсэн. Иймээс дээрх судлаачдын бүтээлийг уншиж, тэнд хэрэглэсэн арга, гарсан үр дүнг нарийвчлан судлах нь чухал юм.

Тав. Социологийн сэтгэлгээний соёл. Нийгмийг шинэчлэхийн тулд хүмүүсийн ухамсар сэтгэлгээг шинэчлэх тухай их ярьж байна. Аливаа асуудлыг ойлгож, зөв шийдвэрлэх арга барилыг эзэмшүүлэхэд социологийн сэтгэлгээ чухал үүрэгтэй. Онол парадигм бүрт социологийн сэтгэлгээний өвөрмөц хэв маяг байна. Тэдгээрийг тэр нь сайн энэ нь муу гэж дүгнэх боломжгүй. Социологийн сэтгэлгээ нь социологийн боловсролоор төдийгүй амьдралын туршлагад тулгуурлан буй болно. Мэргэжлийн социологийн дипломтой хэрнээ социологийн сэтгэлгээг төдийлөн эзэмшээгүй социологич байхыг үгүйсгэх аргагүй. Социологийн сэтгэлгээ нь зөвхөн социологичид төдийгүй, өргөн олон нийтэд, ялангуяа төр засгийн удирдах ажилтан түүнийг сайн эзэмших нь чухал гэдгийг нэртэй социологичид тэмдэглэжээ. Иймд ялангуяа социологийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтад социологийн сэтгэлгээг эзэмшүүлэхэд илүү анхаарах шаардлага гарч буй.

М. Веберийн нийгмийн үйлдлийн парадигм байна. Аливаа зүйлийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, хөрөнгийг тооцохгүйгээр зорилго болгон тунхаглаж болохгүй. Бүгдийг нягт нямбай тооцоолж бодох ёстой. Ялангуяа гарч болзошгүй сөрөг дагаварыг тооцох шаардлагатай. Энэ бол социологийн

4 Монголын соёлын түүх. Нэгдүгээр дэвтэр. Уб., 2001. 137 дахь тал.

5 Төв үзлийн арга зүй // Г. Лувсанцэрэн. Буддын гүн ухааны онол түүхийн асуудлаас. Уб., 2008. 142 дахь тал.

6 Ч. Ган-Өлзий. Оюунлаг танин мэдэхүйн үндэсний уламжлал ба онцлог // Оюунлаг танин мэдэхүй. Уб., 2011. 173 дахь тал.

сэтгэлгээний жишээ<sup>7</sup>. Төр засгийн удирдлагууд гаргаж буй шийдвэрийнхээ нийгэмд үзүүлэх үр нөлөөлөл, гарч болох эерэг сөрөг үр дагаварыг судалгаанд тулгуурлан урьдчилан харж чаддаг чадвартай болбол, алдаатай шийдвэр гарахгүй байхсан. Энэ нь хожмоо функциональ шинжилгээнд улам нарийвчлагдан тусгагдсан байдаг.

Аливаа үйл явцыг судлахдаа түүний үүсэн буй болсон тэрхүү нөхцөл байдал, тодорхой орон зай цаг хугацаатай холбон үзүүштэй. Судалгаа явуулахдаа ч социологийн хөгжлийн олон улсын чиг хандлагыг харгалзан үзэхийн зэрэгцээ Монгол үндэстний менталитет, нийгмийн соёл сэтгэлгээний уламжлалыг анхааран үзэж түүнд нийцүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэх учиртай. Иймээс социологичид Монголын онцлог хүн ардын соёл, унаган төрхийг дутуу харгалзах, эх түүхээ таньж мэдээгүйгээс буруу дүгнэлтэд хүрч болохыг анхаарах ёстой.

Бидэнд гадаад орны судалгааны аргачлал үр дүнг шууд ашиглах явдал гарч байна. Гэтэл Монголын малчдаас асуух асуулт нь Оросын тариачдаас асуух асуулттай ижилхэн байж таарахгүй. Монголын хөдөөг Оросын хөдөөтэй адилтгах аргагүй. Түүнчлэн аливаа онол үзэл баримтлалыг Монголын нөхцөлд тохирч буйг нотлон харуулах гэхээсээ илүүтэйгээр таарч тохирохгүй байгаа талыг нь жишээ баримтаар илрүүлэхэд анхаарлаа хандуулах нь чухал байж болох юм.

Социологийн соёлын олон улсын стандарт хараахан боловсрогдоогүй байна. Зарим социологичид социологийн соёл илүү хөгжсөн орны тоонд АНУ, Англи, Франц, Польш, Скандиновын орнууд, Бразил, Японыг оруулсан байна<sup>8</sup>. Бид тэднээс суралцах хэрэгтэй юм.

Зургаа. Социологи, нийгэм, засаглалын уялдаа холбоо. Социологичид төр засгийн шийдвэр гаргахад нөлөөтэй хүмүүсийн тэргүүн эгнээнд явдаг байх ёстой. “Ямар нийгэм байна, тийм засаглал байна, Ямар засаглал байна, тийм социологи байна” гэж ярих нь бий. Пост социалист орнуудад социологи засаглал хоёрын хооронд харилцан ашигтай, хоршин ажиллах зарчимд тулгуурласан харилцаа бий болоогүй, харин ч таатай бус хандлага илэрсээр байгааг судлаач эрдэмтэд тэмдэглэсэн байна<sup>9</sup>. Манайд ч ийм байгаа.

Үүнтэй уялдан социологичдын дуу хоолойг нийгэм болон засаг төрд хүргэхэд Монголын социологичдын холбооны дүрэм, бүтэц, чиг үүргийг шинэчлэн зохион байгуулах явдал чухал ач холбогдолтой юм. Ялангуяа социологийн судалгаа явуулдаг олон төв, хүрээлэн, тэнхимүүдийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, судалгааны арга зүй аргачлалаа боловсронгуй болгоход тэдэнд туслах, социологичдыг дэлхийн социологичдын холбоо, сүлжээнд оруулах, гадаадад мэргэжил дээшлүүлэх, гадаадын нэр хүндтэй сургууль, хүрээлэн, судалгааны төв, сэтгүүлийн газартай холбоо тогтоох, социологийн тоон төдийгүй чанарлаг мэдээллийн найдвартай санг Монголд буй болгох зэрэг олон чухал асуудал шийдлээ хүлээсээр байна.

“Том төрөөс ухаалаг төр лүү” зөвлөгөөн дээр ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монголын төрд байгаа 8 буруугийн нэгэнд “Туршлага байвал судалгаа онол хэрэггүй” гэсэн үзэл бодлыг оруулсан нь оновчтой болжээ гэж хэлмээр байна. Ухаалаг төрд шилжих аваас социологичид төртэйгээ илүү холбоотой ажиллах нөхцөл бүрдэх байх гэсэн төсөөлөл төрнө.

Нэг талаас социологичид олон нийтэд юу хийж байгаагаа байнга мэдээлж, тэдэнд ойлгомжтой байдлаар судалгааны дүнгээ нийтэлж байх, судалгааны дүнгийн талаар судлагдсан хүмүүстээ ямар нэг байдлаар мэдээлдэг байх нөгөө талаас бидний хийж буй судалгаа нийгмийн үзэгдлийг олон хүчин зүйлийн төвөгтэй нөлөөлөл холбоо шүтэлцээнд нь нарийвчлан судалсан шинэ мэдлэг өгөхүйц байхыг нийгмийн зүгээс шаардаж байна.

Олон судлаачид Ази, Европ, Америк, Австрали тивд Өрнөдийн болон Европын орнуудад мэргэжил дээшлүүлж, төсөлд оролцож, зарим нь эрдмийн зэрэг хамгаалж, зарим эрдэмтэн хувийн зардлаараа социологичдын их хуралд хүртэл оролцсон байна. Тэднээс суралцах олж мэдсэн зүйлийг яриулах, санал солилцох ажлыг тогтмолжуулмаар санагдана. Ер нь социологичид хүрээлэнгийн сектор, их дээд сургуулийн тэнхимүүд, судалгааны төвүүд байнгын холбоотой ажиллахыг нийгмийн амьдрал

7 А.Г Здравосмыслов. Несколько критических замечаний по итогам пленарного заседания Всероссийского социологического конгресса. Социологический журнал. 2008. №4. С. 143.

8 А.Г Здравосмыслов. К вопросу о культуре социологического мышления // Социс. 2008. № 5. С. 7.

9 М.К Горшков. Российская социология: между обществом и властью // социс. 2012. № 7. С. 23.

шаардах болов. Үнэнээ хэлэхэд бид олон түмэнд танигдахын тулд бусад социологичид юу хийж бүтээж байгааг мэдэх, харилцан бие биенээсээ суралцах хэрэгтэй. Бид тулгарч буй бэрхшээл, гарч байгаа ололт, илэрч буй дутагдлаа байнга хэлэлцэж байх шаардлагатай мэт санагдаж байна.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд хуучин уламжлал болгон хийж байсан социологичдын симпозиумыг сэргээн хийх, төвөгтэй асуудлаар санал солилцох, судалгааны дэвшилтэт арга барил, шинэлэг санаа дүгнэлтийг шүүн хэлэлцэх зэргээр шинийг байнга эрэлхийлэх хэрэгтэй болж байгааг сануулахад илүүдэхгүй.